# САНГИЙН САЙД, ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1998 оны 10 дугаар сарын 01-ны өдөр

Дугаар 225/214

Улаанбаатар хот

Сургалтын зардлын тухай

ТУШААХ НЬ:

1.Гэгээрлийн сайдын 1997 оны 333, 1998 оны 78, 194, 198, 203 тоот тушаалуудад дурдсан хавсралтад заасан 10 суралцагчийн сургалтын төлбөр ба тэтгэлгийн жилийн зардлыг "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-д хамруулан санхүүжүүлэхийг Төсвийн бодлогын газар /Л.Дашдорж/-т зөвшөөрсүгэй.

2.Цаашид өндөр хөгжилтэй орнуудад хүн сургахтай холбогдсон журмыг хатуу баримталж ажиллахыг Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Алтангэрэл/-т даалгасугай.

3.Энэ тушаалын хавсралтад дурдсан 10 суралцагчтай нэг жилийн сургалтын гэрээ байгуулж холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Танбат/-д зөвшөөрсүгэй.

САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТБАЯР

ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н.САЙХАНБИЛЭГ

Сангийн сайд, Гэгээрлийн сайдын
1998 оны 325/214 тоот хамтарсан
тушаалын хавсралт

| № | Овог нэр | Гэгээрлийн сайдын тушаалын дугаар | Суралцах улс, сургууль |
|---|---|---|---|
| 1. | Гарьд Тэнүүн | 1998.08.06 № 178 | АНУ,Рютгэрийн их сургууль |
| 2. | Данцэрэн Лхамаа | -"- | АНУ,Калифорны их сургуулийн Бээжин дахь салбар |
| 3. | Пүрэвдорж Батчулуун | 1997.12.11 № 333<br>1997.12.12 | Канад,Норфен коллеж |
| 4. | Баатар Батбаяр | -"- | -"- |
| 5. | Зундуйсүрэн Ган-Очир | -"- | -"- |
| 6. | Гомбожав Датаатунгаа | 1998.08.20 № 194 | Англи,Манчестрийн их сургууль |
| 7. | Дэлгэрнасан Оюунчимэг | 1998.09.01 № 203 | БНХАУ,ӨМӨЗО,Ана гаахын дээд сургууль |
| 8. | Гэрэлчулуун Билгүүн | 1998.08.25 № 198 | АНУ-ын Ютагийн улсын коллеж |
| 9. | Баасанжав Алтанцэцэг | -"- | -"- |
| 10 | Өлзийбаяр Мөнгөнсарнай | -"- | -"- |